



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар A/143

Бор-Өндөр сум

**Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалт, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.4 дахь заалт, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын 1, 2, 4 дүгээр багт “Хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээ хийх” ажлыг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан “Ганзам ложистик” ХХК-д үлдэгдэл 30 хувийн санхүүжилт болох 5,970,000 (таван сая есөн зуун далан мянга) төгрөгийг олгосугай.

2. Тус ажлын үлдэгдэл 30 хувийн санхүүжилт болох 5,970,000 (таван сая есөн зуун далан мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг Санхүүгийн албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ